

2025 ОНЫ 1 ДҮГЭЭР САР

## МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ БА СОНГУУЛЬ

Судлаач Д.Баярмаа

Монгол Улсын төсвийн зардал УИХ-ын ээлжит сонгуулийн өмнөх жилүүдэд их хэмжээгээр өсөх, хөрөнгө оруулалтын олон төслийг шинээр эхлүүлэх, улмаар эдгээр төслийн эхний санхүүжилтийг хэт бага төлөвлөснөөс төслийн хэрэгжилт удааширч, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах зэрэг асуудлууд ажиглагдаж байна. Иймд сонгуулийн болон сонгуулийн бус жилүүд дэх хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийлээ. Энэхүү судалгаанд сүүлийн 12 жилийн хугацаан дахь буюу 2012-2024 онууд дахь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын шинэ төслүүдийн төлөвлөлтийг хамрууллаа.

**Сонгуулийн жилүүдэд улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн тоо, нийт төсөвт өртөг нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.**


Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хуульд<sup>1</sup> тусгагдсан хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийг судлахад УИХ-ын сонгуулийн жилүүд болох 2012, 2020, 2024 онуудад шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо, нийт төсөвт өртөг нэмэгдсэн байна (Зураг 1, Зураг 2).

2012 оны сонгуулийн жилд хамгийн олон буюу хөрөнгө оруулалтын 1276 төсөл шинээр хэрэгжүүлэхээр баталжээ. Сонгуулийн дараа 2013-2017 онуудад

шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо огцом буурч, 2017 онд 30 болсон байна. 2018 оноос хойш шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо дахин өссөн боловч 2020 оны сонгуулийн жилийн дараа дахин буурч 2023 онд 10 буюу хамгийн бага түвшинд хүрсэн.

Харин 2024 оны сонгуулийн жилд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо эргэн өсөж 712 болсон байна.

**Зураг 1. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн тоо**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль


1. Legalinfo.mn цахим хуудсанд нийтлэгдсэн төсвийн тодотголууд хийгдсэний дараах тоо баримтыг судалгаанд ашиглав.

\* Талархал: Агуулгад санал, шүүмж өгсөн Нээлттэй Нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд талархал илэрхийлж байна.

Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртөг 2012 онд 1.69 их наяд төгрөг байсан бол 2013-2017 онд тасралтгүй буурсан. 2015-2017 онд хамгийн бага түвшинд буюу 108-179 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзсэн байна (Зураг 2). 2018 оноос төсвийн хөрөнгө оруулалтын идэвхжил нэмэгдэж, 2018-2024 онд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртөг дахин өссөн. Тухайлбал, 2022 онд 2.96 их наяд төгрөг, 2024 онд 5.97 их наяд төгрөг болж хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.

Харин 2016 оны сонгуулийн жилд бусад сонгуулийн жилүүдтэй харьцуулахад шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдэд хамгийн бага санхүүжилт хийгдсэн. Үүнийг тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн хязгаарлалтаас шалтгаалсан гэж үзэж болох юм. 2020 оны сонгуулийн жилд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хүндрэлийн үед байсан ч шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо, нийт төсөвт өртөг өндөр хэвээр байсан.

**Зураг 2. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртөг (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

2024 оны сонгуулийн жилд шинээр хэрэгжих төслүүдийн нийт төсөвт өртөг хамгийн өндөр түвшинд хүрсэн бөгөөд энэ сонгуультай холбоотойгоор сонгогчдод нөлөөлөх зорилготой хөрөнгө оруулалтын идэвхжил байж магад гэж дүгнэж болох юм. Мөн өмнөх жил буюу 2023 онд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо маш бага байгаа нь сонгуулийн жил болох 2024 оны

өмнөхөн төсвийн хэмнэлтийн бодлого баримталж, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн хуваарилалтыг дараа жил рүү шилжүүлсэнтэй холбоотой байж болох юм. Цаашид төсвийн төлөвлөлтөд улс төрийн нөлөөллийг бууруулах, эдийн засгийн бодлогын тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

**Сонгуулийн болон сонгуулийн бус жилүүдэд шинээр хэрэгжүүлэх төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөхгүй байна.**

Засгийн газар жилийн төсвийн төсөлд шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хэрэгжүүлэх хугацаанд нь тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй дүнтэй эхний санхүүжилтийг тусгах шаардлага Төсвийн тухай хуулийн 29.3.5-д бий.

төлөвлөөгүй буюу санхүүжилтийн шаардлага хангаагүй төслийн тоо олон байна.

2012-2024 онд сонгуулийн болон сонгуулийн бус жилийг үл харгалзан улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн дагуу

Эхний санхүүжилтийг шаардагдах түвшингээс багаар төлөвлөсөн шинээр хэрэгжих төслийн нийт шинээр хэрэгжих төслийн тоонд эзлэх хувийн жин 2012 онд 15.9 хувь, 2013 онд 25.8 хувь, 2014 онд 10.5 хувь, 2015 онд 21.5 хувь, 2016 онд 12.5 хувь, 2018 онд 28.8 хувь, 2019 онд 18.8 хувь, 2020 онд 39.9 хувь, 2021 онд 40.8 хувь, 2022 онд 66.6 хувь, 2023 онд 20 хувь, 2024 онд 37.6 хувь байна (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан санхүүжилтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төслийн тоо, хувийн жин**


	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Санхүүжилтийн шаардлага хангаагүй төслийн тоо	203	124	32	14	6	0	183	171	337	187	442	2	268
Санхүүжилтийн шаардлага хангаагүй төслийн нийт шинээр хэрэгжих төслийн тоонд эзлэх хувийн жин	15.9%	25.8%	10.5%	21.5%	12.5%	0.0%	28.8%	18.8%	39.9%	40.8%	66.6%	20.0%	37.6%

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

Шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийн нийт төсөвт өртөгт эзлэх хувийн жин 2012 онд 53 хувь, 2013 онд 62.2 хувь, 2014 онд 60.6 хувь, 2015 онд 67.9 хувь, 2016 онд 61.6 хувь, 2017 онд 93.9 хувь, 2018 онд 46.6 хувь, 2019 онд 56.1 хувь, 2020 онд 30.5 хувь, 2021 онд 13.2 хувь, 2022 онд 18.9 хувь,

2023 онд 76.7 хувь, 2024 онд 38.7 хувь байна (Зураг 3). 2018-2022 онд шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийн нийт төсөвт өртөгт эзлэх хувийн жин өмнөх жилүүдтэй харьцуулахад буурч, 2021 онд хамгийн бага түвшинд буюу 13.2 хувьд хүрч байжээ.

**Зураг 3. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийн нийт төсөвт өртөгт эзлэх хувийн жин**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

Хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг бага төлөвлөх нь уг төслийн үлдэгдэл санхүүжилтийг дараа дараагийн жилүүдэд ихээхэн дүнтэйгээр төлөвлөх шаардлагыг бий болгож, улмаар барилга байгууламж он дамжин олон жил

хэрэгжих, төслийн төсөвт өртөг нэмэгдэх, төсвийн хөрөнгийн үргүй зардал бий болох зэрэг эрсдэлүүд бий болгож байна. Иймд улсын төсөвт туссан хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөх хэрэгтэй байна.

**Төсвийн бодлого тогтворгүй, төсвийн тооцоолол бодитой бус байна.**

Монгол Улс 2012 оноос хойш 2012, 2018, 2019 оныг эс тооцвол бүх онуудад 1-2 удаа төсвөө тодотгож ирсэн нь төсвийн бодлого тогтворгүй, төсвийн тооцоолол бодитой бус байсныг илтгэж байна. Тодруулбал, 2013, 2016, 2020, 2021, 2023, 2024 оны төсөвт тус бүр 1 удаа, 2014, 2015, 2017, 2022 оны

төсөв 2 удаа тус тус тодотгол хийгджээ (Хүснэгт 2). Жишээ болгож 2024 оны төсвийн тодотголыг авч үзвэл анх батлагдсан хөрөнгө оруулалтын 692 төслөөс 31.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл хасагдаж, 982.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл нэмэгджээ.

## Хүснэгт 2. Төсвийн тодотгол хийгдсэн байдал

Он	Төсвийн тодотгол хийгдсэн байдал	Тодотгол хийгдсэн хугацаа
2012	Хийгдээгүй	
2013	1 удаа	2013.10.25
2014	2 удаа	2014.05.23, 2014.12.18
2015	2 удаа	2015.01.23, 2015.10.30
2016	1 удаа	2016.09.09
2017	2 удаа	2017.04.14, 2017.10.26
2018	Хийгдээгүй	
2019	Хийгдээгүй	
2020	1 удаа	2020.08.28
2021	1 удаа	2021.07.07
2022	2 удаа	2022.01.31, 2022.04.29
2023	1 удаа	2023.06.16
2024	1 удаа	2024.08.30

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

### Төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эдийн засгийн ангилалд сонгуулийн жил нөлөөлж байна.

2012-2024 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг эдийн засгийн ангилал (барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ)-аар авч үзэхэд 2012, 2020, 2024 оны сонгуулийн жилүүдэд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт эзлэх барилга байгууламжийн хувийн жин бусад жилүүдтэй харьцуулахад өндөр байх хандлага ажиглагдаж

байна (Хүснэгт 3). Энэ нь иргэдийн амьдралд шууд нөлөөлөл үзүүлэх боломжтой барилга, дэд бүтцийн томоохон төслүүдийг төсөвт тусгаж сонгогчдод эерэг сэтгэгдэл төрүүлж, санал авахад чиглэсэн сонгуулийн бодлоготой холбоотой байж болох юм. Энэ нь тухайн үеийн сонгуулийн үр дүнд нөлөөлж болох ч урт хугацааны төсвийн бодлого, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж болзошгүй байдаг.

### Хүснэгт 3. Монгол Улсын 2012-2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эдийн засгийн ангилал (нийт төсөвт өртөгт эзлэх хувийн жин)

Эдийн засгийн ангилал	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Барилга байгууламж	86.3%	61.5%	81.0%	28.9%	30.1%	56.9%	84.6%	85.6%	85.3%	69.5%	88.8%	34.1%	85.7%
Их засвар	3.8%	16.5%	8.6%	35.2%	46.8%	18.3%	8.5%	6.7%	6.8%	6.1%	3.7%	5.3%	0.8%
Тоног төхөөрөмж	9.9%	14.4%	10.4%	36.0%	23.2%	24.8%	5.2%	7.5%	6.6%	22.9%	6.9%	54.6%	8.2%
ТЭЗҮ	0.0%	7.6%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.7%	0.2%	1.3%	1.5%	0.5%	6.0%	5.3%

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

2012 оны сонгуулийн жилд шинээр хэрэгжих барилга байгууламжийн нийт төсөвт өртөг өндөр буюу 1.46 их наяд төгрөг, хувийн жин 86.8 хувь байсан нь сонгуулийн нөлөө болон өмнөх 2011 оны эдийн засгийн өндөр өсөлттэй<sup>2</sup> холбоотой


байж, томоохон төслүүдийг эхлүүлэхэд чиглэсэн байж магадгүй юм. 2013-2014 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн нийт төсөвт өртөг 2012 оныхтой харьцуулахад буурсан (2013 онд 555.6 тэрбум төгрөг, 2014 онд 659.7 тэрбум

2 Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээр дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ огцом өсөж, Монгол улсын экспорт нэмэгдэн, эдийн засгийн өсөлт 2011 онд хамгийн өндөр буюу 17.3 хувьд хүрсэн. Дэлхийн санхүү эдийн засгийн хүндрэл, уул, уурхай олборлох салбарын түүхий эдийн үнийн тасралтгүй уналт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт зэргээс шалтгаалан 2012-2016 онуудад эдийн засгийн өсөлт 12.3-1.2 хувь хүртэл буурсан. 2017-2019 онуудад 5.6-7.7 хувиар өсч, 2020 онд -4.6 хувиар буурч, 2021-2023 онд 1.6-7.4 хувь өсчээ.

төгрөг) боловч энэ хугацаанд тухайн жилийн шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртөгт эзлэх хувийн жин өндөр хэвээр (2013 онд 61.5 хувь, 2015 онд 81.0 хувь) байв. 2015-2016 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсөвт өртөг эрс буурч (2015 онд 31.2 тэрбум төгрөг, 2016 онд 51.9 тэрбум төгрөг), хувийн жин багассан (2015 онд 28.9 хувь, 2016 онд 30.1 хувь). Энэ нь эдийн засгийн удаашрал,

төсвийн хязгаарлалтаас үүдэлтэй байж болох юм. 2017 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсвийн хөрөнгө оруулалт бага зэргийн өсөлттэй байсан (нийт төсөвт өртөг 102.0 тэрбум төгрөг, хувийн жин 56.9 хувь). 2018-2019 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсөвт өртөг эрс өсч (2018 онд 969.3 тэрбум төгрөг, 2019 онд 1.62 их наяд төгрөг), хувийн жин нэмэгдсэн (2018 онд 84.6, 2019 онд 85.6 хувь).

**Зураг 4. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан барилга байгууламжийн тоо**




Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

Эдийн засгийн тогтвортой өсөлт энэ өсөлттэй холбоотой байж болно. 2020 оны сонгуулийн жилд хэдий цар тахлын нөлөө, эдийн засгийн бууралттай үе байсан ч шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсөвт өртөг болон хувийн жин харьцангуй өндөр хэвээр байсан (төсөвт өртөг 1.54 их наяд төгрөг, хувийн жин 85.3 хувь). Сонгуулийн дараах 2021 онд барилга байгууламжийн төсвийн хөрөнгө оруулалт эрс буурсан (нийт төсөвт өртөг 651.5 тэрбум төгрөг, хувийн жин 69.5 хувь). 2022 онд барилга байгууламжийн төсвийн хөрөнгө оруулалт эрс өссөн (нийт төсөвт өртөг, 2.62 их наяд төгрөг,

хувийн жин 88.8 хувь). Гэвч 2023 онд шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсвийн хөрөнгө оруулалт эрс буурсан (нийт төсөвт өртөг 228.9 тэрбум төгрөг, хувийн жин 34.1 хувь). 2024 оны сонгуулийн жилд шинээр хэрэгжих барилга байгууламжийн нийт төсөвт өртөг хамгийн өндөр буюу 5.11 их наяд төгрөг, хувийн жин 85.7 байна.

Шинээр хэрэгжих барилга байгууламжийн төслийн тоо 2012 онд хамгийн их буюу 912, 2013 онд 165, 2014 онд 183, 2015 онд 29, 2016 онд 22, 2017 онд 11, 2018 онд 457, 2019 онд 659, 2020 онд 444, 2021 онд 257, 2022 онд 447, 2023 онд хамгийн бага буюу 3, 2024 онд 464 байна (Зураг 4).

**Зураг 5. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

**Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн дийлэнх хувь эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалт, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн салбарт салбарт ногдож байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хуваарилалт нь тухайн жилд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн тэргүүлэх чиглэлүүдийг харуулах боломжтой. Иймд 2012-2024 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртгийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзлээ. 2012-2024 онд төсвийн ерөнхийлөн захирагчдын нэр, бүтцэд ихээхэн өөрчлөлтүүд орж байсан тул салбараар тооцоолол хийж харьцууллаа. Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртгийн дийлэнх хувь боловсрол, соёл, шинжлэх ухаан, зам тээвэр, эрчим хүч барилга, хот байгуулалт, эрүүл мэнд, хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ногдож байна. Мөн Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол улсын Ерөнхий сайд нарын багцад

шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүд олон багтжээ. Гэвч эдгээр салбар, төсвийн ерөнхийлөн захирагчдын хувийн жин 2012-2024 онд ихээхэн хэлбэлзэлтэй байна (Хүснэгт 4).

Тухайлбал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт ногдох хувийн жин сонгуулийн жилүүдийн дараа буурч байсан байна. 2012 оны сонгуулийн жилд хувийн жин 13.2 хувь байсан бол 2013 онд 5.4 хувь, 2016 оны сонгуулийн жилд 21.2 хувь байсан бол 2017 онд 15 хувь, 2020 оны сонгуулийн жилд 52 хувь байсан бол 2021 онд 27.8 хувь болж тус тус буурч байжээ.

Зам тээврийн салбарын хувьд мөн энэ байдал ажиглагдаж байгаа бөгөөд 2012 оны сонгуулийн жилд хувийн жин 36.2 хувь байсан бол 2013 онд 13.5 хувь, 2016 оны сонгуулийн жилд 44.2 хувь байсан бол 2017 онд 0 хувь болж буурч байжээ.

**Хүснэгт 4. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, голлох салбар, төсвийн ерөнхийлөн захирагчдаар (хувийн жин)**

Салбар, ТЕЗ	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Дундаж
Боловсрол, соёл, шинжлэх ухаан	13.2%	5.4%	22.5%	29.6%	21.2%	15%	39.7%	31.7%	52%	27.8%	22.8%	0.0%	20.6%	23.2%
Зам тээвэр	36.2%	13.5%	17.7%	16.7%	44.2%	0.0%	9.4%	26.6%	8.8%	8.9%	28.1%	5.3%	27.9%	18.7%
Эрчим хүч	7.3%	6.6%	25.7%	1.9%	0.1%	45.9%	8.8%	4.9%	3.6%	2.8%	6.3%	20.6%	3.3%	10.6%
Барилга, хот байгуулалт	5.7%	26.6%	13.5%	0.0%	2.9%	1.1%	13.5%	7.8%	10.4%	12.2%	19.7%	0.0%	7.1%	9.3%
Эрүүл мэнд	6.0%	6.6%	4.3%	26.7%	9.1%	13.4%	7.6%	5.9%	5.9%	16.2%	6.6%	0.0%	6.7%	8.8%
Хүнс, хөдөө аж, ахуй, хөнгөн үйлдвэр	5.3%	0.0%	5.4%	0.2%	0.1%	11.2%	3.1%	1.3%	1.4%	4.1%	3.6%	0.0%	1.8%	2.9%
Сангийн сайд	2.5%	1.5%	2.7%	0.0%	0.0%	6.3%	6.1%	8.8%	4.2%	7.4%	2.5%	0.0%	9.8%	4.0%
Хууль зүй, дотоод хэргийн сайд	2.3%	4.4%	0.6%	12.1%	3.9%	3.4%	5.2%	2.3%	2.0%	4.4%	3.0%	2.8%	2.3%	3.7%
Монгол улсын Ерөнхий сайд	7.8%	14.0%	1.1%	0.0%	4.7%	0.0%	0.5%	2.0%	5.5%	3.7%	1.1%	0.0%	0.0%	3.1%

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

\* 2012-2024 онд төсвийн ерөнхийлөн захирагчдын нэр, бүтцэд ихээхэн өөрчлөлтүүд орж байсан тул салбараар тооцоолол хийв. Тухайлбал, 2012 оны "Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд"-ын шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдээс зам тээврийн салбарт хамаарах төслүүдийн хувийн жинг тооцох г.м

Эрчим хүчний салбарын хувьд ногдох хувийн жин 2014, 2017, 2023 онуудад харьцангуй өндөр буюу 20.6-45.9 хувь байсан бол 2015, 2016, 2020, 2021, 2024 онуудад хувийн жин харьцангуй бага буюу 0.1-3.6 хувь байна.

Барилга, хот байгуулалтын салбарт ногдох хувийн жин 2013, 2014, 2018, 2020, 2022 онуудад харьцангуй өндөр буюу 10.4-26.6 хувь байгаа бол 2015, 2016, 2017, 2023 онуудад хувийн жин харьцангуй бага буюу 0-2.9 хувь байна. Эрүүл мэндийн салбарт ногдох

хувийн жин 2015, 2017, 2021 онуудад харьцангуй өндөр буюу 13.4-26.7 хувь, бусад жилүүдэд ихэвчлэн 10 хувиас доогуур түвшинд байна. Хүнс, хөдөө аж,


ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт ногдох хувийн жин 2017 онд хамгийн өндөр буюу 11.2 хувь байсан бол бусад жилүүдэд 0-5.4 хувь байна.

**Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийг аймаг, дүүргүүдэд тэгш бус байдлаар төлөвлөж байна.**

2012-2024 онд аймгуудад шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн жилийн дундаж хэмжээг тооцож (сүүлийн 12 жилийн дундаж) харьцуулбал Хэнтий аймагт хамгийн өндөр буюу жилд дунджаар нийт 114 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төслүүд батлагдсан бол Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу жилд дунджаар 10.4 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төслүүд батлагдсан байна. Энэ нь Хэнтий аймагтай харьцуулахад 11 дахин бага дүн юм (Зураг 6). Бусад аймагт жилд дунджаар ногдож буй шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийг дарааллаар нь авч үзвэл Ховд аймаг 63.6 тэрбум төгрөг, Төв аймаг 63.5 тэрбум төгрөг,

Дархан-Уул аймаг 45.4 тэрбум төгрөг, Хөвсгөл аймаг 43. тэрбум төгрөг, Өвөрхангай аймаг 43. тэрбум төгрөг, Дорнод аймаг 40.1 тэрбум төгрөг, Баянхонгор аймаг, 31.2 тэрбум төгрөг, Завхан аймаг 31.2 тэрбум төгрөг, Увс аймаг 29.8 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймаг 27.9 тэрбум төгрөг, Баян-Өлгий аймаг 24.1 тэрбум төгрөг, Говь-Алтай аймаг 22.7 тэрбум төгрөг, Сүхбаатар аймаг 21.2 тэрбум төгрөг, Дорноговь аймаг 20.1 тэрбум төгрөг, Орхон аймаг 18.5 тэрбум төгрөг, Булган аймаг 18.4 тэрбум төгрөг, Дундговь аймаг 13.6 тэрбум төгрөг, Өмнөговь аймаг 12 тэрбум төгрөг байна. Эндээс харвал шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийг аймгуудад тэгш бус байдлаар төлөвлөж байна гэж дүгнэж болох юм.

**Зураг 6. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр аймгуудад шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн жилийн дундаж төсөвт өртөг (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

\* Аль аймагт хэрэгжихийг тодорхой зааж өгөөгүй, эсвэл хэд хэдэн аймагт хамт хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн жилийн дундаж төсөвт өртгийг "Аймгуудад" гэсэн ангилалд тооцов.


2012-2024 онд Улаанбаатар хотын дүүргүүдэд шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн жилийн дундаж хэмжээг тооцож харьцуулбал Налайх дүүрэгт хамгийн өндөр буюу жилд дунджаар нийт 56.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төслүүд батлагдсан бол Багахангай дүүрэгт хамгийн бага буюу жилд дунджаар 2.1 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төслүүд батлагдсан байна. Энэ нь Налайх дүүрэгтэй харьцуулахад 27 дахин бага дүн юм (Зураг 7).

Нэг хүн амд ногдох шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн жилийн дундаж хэмжээг дээрх 2 дүүргээр авч үзвэл Налайх дүүрэгт 1.4 сая байгаа бол Багахангай дүүрэгт 3 дахин бага буюу 475.5 мянган төгрөг байна. Бусад дүүрэгт жилд дунджаар ногдож буй шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийг дарааллаар нь авч үзвэл Сүхбаатар дүүрэг 51.5 тэрбум төгрөг, Баянзүрх дүүрэг 43.7 тэрбум төгрөг, Хан-Уул дүүрэг 39.3 тэрбум төгрөг, Сонгинохайрхан дүүрэг 34.2 тэрбум төгрөг, Чингэлтэй дүүрэг 32.8 тэрбум төгрөг,

Баянгол дүүрэг 30.1 тэрбум төгрөг, Багануур дүүрэг 5.6 тэрбум төгрөг байна. Сонгуулийн жилээр авч үзвэл 2012 онд Өвөрхангай, Төв, 2016 онд Завхан, Хэнтий, 2020 онд Дорнод, Хэнтий, 2024 онд

Хэнтий, Ховд аймгуудад шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртөг бусад аймгуудтай харьцуулахад өндөр байна (Хавсралт 4).

**Зураг 7. Монгол Улсын 2012-2024 оны төсвийн санхүүжилтээр дүүргүүдэд шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн жилийн дундаж төсөвт өртөг (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

\* Аль дүүрэгт хэрэгжихийг тодорхой зааж өгөөгүй, эсвэл хэд хэдэн дүүрэгт болон Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн жилийн дундаж төсөвт өртгийг "Улаанбаатар" гэсэн ангилалд тооцов.

2012-2014 оны шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн жагсаалтад хаана хэрэгжих байршлыг тодорхой заагаагүй олон төслүүд байна. Тухайлбал, 2012 онд 222 төсөл, 2013 онд 176 төсөл, 2014 онд 44 төслийн байршлыг тодорхойг заагаагүй байна. Сонгуулийн жилээр авч үзвэл 2012 онд Баянзүрх, Сонгинохайрхан,

Чингэлтэй, 2016 онд Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, 2020 онд Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, 2024 онд Налайх, Сүхбаатар дүүргүүдэд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртөг бусад дүүргүүдтэй харьцуулахад өндөр байна (Хавсралт 4).

**Барилга байгууламжийн төрөл**

2012-2024 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан барилга байгууламжийн зарим төрлийн нийт төсөвт өртгийн 1 жилд ногдох дундаж хэмжээг тооцож үзвэл авто зам 146.3 тэрбум, сургуулийн барилга, өргөтгөл, шинэчлэл 81.5 тэрбум төгрөг, цэцэрлэгийн барилга, өргөтгөл 55.2 тэрбум төгрөг, цахилгаан станц, цахилгаан хангамж, цахилгааны шугам сүлжээ 40.6 тэрбум төгрөг, инженерийн шугам сүлжээ 32.5 тэрбум төгрөг, дулааны станц, дулаан хангамж, дулааны

шугам сүлжээ 28.3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн төвийн барилга 20.9 тэрбум төгрөг, спортын заал, ордон, төв цогцолборын барилга 17.2 тэрбум төгрөг, эмнэлгийн барилга, өргөтгөл, шинэчлэл 16.7 тэрбум төгрөг, сургуулийн дотуур байрны барилга, өргөтгөл, шинэчлэл 16.4 тэрбум төгрөг, цэвэр, бохир усны шугам сүлжээ 11.8 тэрбум төгрөг, сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга 10.4 тэрбум төгрөг байна (Зураг 8).



**Зураг 8. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр дүүргүүдэд шинээр хэрэгжихээр батлагдсан зарим төрлийн барилга байгууламжийн жилийн дундаж төсөвт өртөг (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

Сонгуулийн жилээр авч үзвэл 2012 онд авто зам, цахилгаан станц, цахилгаан хангамж, цахилгааны шугам, сүлжээ, 2016 онд сургуулийн барилга, өргөтгөл, шинэчлэл, 2020 онд авто зам, сургуулийн

барилга, өргөтгөл, шинэчлэл, 2024 онд авто зам, сургууль ба цэцэрлэгийн барилгын өргөтгөл, шинэчлэлийн нийт төсөвт өртөг харьцангуй өндөр байна (Хүснэгт 5).

**Хүснэгт 5. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан барилга, байгууламжийн зарим төрлийн нийт төсөвт өртөг (тэрбум төгрөг)**

Барилга, байгууламжийн төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Дундаж
Авто зам	220.0	0.0	102.8	0.0	0.0	0.0	54.8	399.8	90.1	62.4	829.6	0.0	141.8	146.3
Сургуулийн барилга, өргөтгөл, шинэчлэл	69.4	4.4	28.7	0.0	12.5	0.0	174.4	228.2	122.0	62.5	244.6	0.0	113.5	81.5
Цэцэрлэгийн барилга, өргөтгөл, шинэчлэл	26.6	1.9	24.5	7.8	0.7	3.5	150.4	132.6	75.9	48.1	142.3	0.0	103.3	55.2
Цахилгаан станц, цахилгаан хангамж, цахилгааны шугам сүлжээ	72.1	19.3	80.0	0.2	0.2	45.5	57.7	39.1	7.9	3.1	154.0	0.0	48.6	40.6
Инженерийн шугам сүлжээ	3.4	68.0	11.7	2.0	1.0	0.0	48.4	46.6	23.1	5.2	192.8	0.0	20.3	32.5
Дулааны станц, дулаан хангамж, дулааны шугам сүлжээ	49.9	33.0	115.3	0.0	0.0	32.3	39.4	1.2	55.8	11.0	14.1	0.0	16.2	28.3
Эрүүл мэндийн төвийн барилга	3.4	11.4	4.8	0.0	0.0	0.0	24.9	40.6	21.0	13.3	111.6	0.0	40.5	20.9
Спортын заал, ордон, төв, цогцолборын барилга	21.5	17.1	14.9	0.9	0.5	0.2	25.9	64.3	25.3	29.5	19.8	0.0	46.6	20.5
Соёлын ордон, төв, цогцолборын барилга	19.6	0.3	6.3	2.5	0.0	0.0	37.6	58.3	21.6	17.4	11.3	0.0	48.6	17.2

Эмнэлгийн барилга, өргөтгөл, шинэчлэл	22.3	1.5	3.1	2.4	2.1	0.0	33.4	56.0	33.6	13.3	33.3	0.0	16.2	16.7
Сургуулийн дотуур байрны барилга, өргөтгөл, шинэчлэл	23.4	0.0	5.1	1.9	0.0	0.0	21.7	41.9	16.5	9.4	56.8	0.0	36.5	16.4
Цэвэр, бохир усны шугам сүлжээ	27.8	19.4	0.0	1.5	0.0	0.0	0.0	12.5	3.8	26.7	50.0	0.0	12.2	11.8
Сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	1.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	10.3	22.1	41.4	3.3	56.9	0.0	0.0	10.4

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

### УИХ-аас төсвийн төслийг хэлэлцэх явцдаа хөрөнгө оруулалтын төслийг нэмсэн байдал

Сонгуулийн жилийн төсвийн төслийг УИХ-аас хэлэлцэх явцдаа хөрөнгө оруулалтын төслийг нэмэх байдал ажиглагддаг. Тухайлбал, Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сард өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төслийг УИХ хэлэлцэх явцдаа 711.2 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй 209 хөрөнгө оруулалтыг төслийг шинээр хэрэгжүүлэхээр

нэмж баталсан байна<sup>3</sup>. 472.8 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй 162 төслийг аймгуудад, 230 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй 44 төслийг нийслэлд шинээр хэрэгжүүлэхээр нэмсэн. Эдгээр төсөлд 2024 онд 235.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн (Хүснэгт 6).

### Хүснэгт 6. УИХ-аас 2024 оны төсвийн төслийг хэлэлцэх явцдаа шинээр хэрэгжүүлэхээр нэмж баталсан хөрөнгө оруулалтын төслүүд, байршлаар (тэрбум төгрөг)

Байршил	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
Аймаг	162	472.8	151.5
Нийслэл	44	230.0	75.2
Улсын хэмжээнд	3	8.4	8.4

Эх сурвалж: Нээлттэй Нийгэм Форум (2023)

Эдийн засгийн ангиллаар авч үзвэл 632.5 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй барилга байгууламжийн 113 төсөл, 2.1 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй их засварын 4 төсөл, 72.6

тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжийн 89 төсөл, 4 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй техник эдийн засгийн үндэслэлийн 3 төсөл нэмэгджээ (Хүснэгт 7).

### Хүснэгт 7. УИХ-аас 2024 оны төсвийн төслийг хэлэлцэх явцдаа шинээр хэрэгжүүлэхээр нэмж баталсан хөрөнгө оруулалтын төслүүд, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)

Ангилал	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
Барилга байгууламж	113	632.5	159.6
Их засвар	4	2.1	1.7
Тоног төхөөрөмж	89	72.6	72.6
ТЭЗҮ	3	4.0	1.3

Эх сурвалж: Нээлттэй Нийгэм Форум (2023)

УИХ-аас төсвийн төслийг хэлэлцэх явцад хөрөнгө оруулалтын төслүүдийг нэмэх нь орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг тусгах зорилготой мэт харагддаг ч бодит байдалд төсвийн сахилга бат, үр ашигт сөргөөр нөлөөлдөг. Энэхүү үйл явц нь улс төрийн тохиролцоо, популизм давамгайлж, эдийн

засгийн бодит шаардлага, төлөвлөлтийн зарчмыг зөрчдөг. Төсвийн төслийг урьдчилан нарийн тооцоолж, шаардлагатай төслүүдийг эхнээс нь тусгаж ажиллах нь төсвийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх чухал алхам юм.

<sup>3</sup> Нээлттэй Нийгэм Форум (2023)

## ТОЙМ ДҮГНЭЛТ

- Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хуульд тусгагдсан хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийг судлахад сонгуулийн жилүүд болох 2012, 2020, 2024 онуудад шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн тоо, нийт төсөвт өртөг нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.
- 2012-2024 онд сонгуулийн болон сонгуулийн бус жилийг үл харгалзан улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөөгүй буюу санхүүжилтийн шаардлага хангаагүй төслийн тоо олон байна.
- Монгол Улс 2012 оноос хойш 2012, 2018, 2019 оныг эс тооцвол бүх онуудад 1-2 удаа төсвөө тодотгож ирсэн нь төсвийн бодлого тогтворгүй, төсвийн тооцоолол бодитой бус байсныг илтгэж байна.
- 2012-2024 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг эдийн засгийн ангилал (барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ)-аар авч үзэхэд 2012, 2020, 2024 оны сонгуулийн жилүүдэд шинээр нийт төсөвт эзлэх барилга байгууламжийн хувийн жин бусад жилүүдтэй харьцуулахад өндөр байх хандлага ажиглагдаж байна.
- Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн нийт төсөвт өртгийн дийлэнх хувь боловсрол, соёл, шинжлэх ухаан, зам тээвэр, эрчим хүч барилга, хот байгуулалт, эрүүл мэнд, хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ногдож байна. Мөн Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол улсын Ерөнхий сайд нарын багцад шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүд олон багтжээ. Гэвч эдгээр салбар, төсвийн ерөнхийлөн захирагчдын хувийн жин 2012-2024 онд ихээхэн хэлбэлзэлтэй байна.
- Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийг аймгуудад тэгш бус байдлаар төлөвлөж байна.
- Сонгуулийн жилүүдэд төсвөөс санхүүжүүлж буй хөрөнгө оруулалтын нийт төсөвт өртөгт авто зам, сургуулийн барилга, өргөтгөл, шинэчлэлийн төслүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.
- Сонгуулийн жилийн төсвийн төслийг УИХ-аас хэлэлцэх явцдаа хөрөнгө оруулалтын төслүүдийг ихээхэн нэмэх байдал ажиглагдаж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль, хавсралтууд
- Үндэсний Статистикийн Хороо
- Нээлттэй нийгэм форум (2023). 2024 оны төсвийн төсөлд тусаагүй боловч УИХ-аас нэмж баталсан хөрөнгө оруулалтын төслүүдийн судалгаа – Инфографик (<https://forum.mn/product/353756>)

**Хавсралт 1. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)**

Он	Барилга байгууламж			Их засвар			Тоног төхөөрөмж			ТЭЗҮ		
	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
2012	912	1459.0	690.2	129	63.6	63.6	235	168.0	142.1	0	0.0	0.0
2013	165	555.6	294.6	172	148.9	124.4	119	130.3	84.1	25	69.0	58.9
2014	183	659.7	341.4	53	69.8	69.1	69	84.9	83.2	0	0.0	0.0
2015	29	31.2	20.2	11	38.0	27.3	25	38.9	25.9	0	0.0	0.0
2016	22	51.9	37.5	11	80.6	31.3	15	39.9	37.4	0	0.0	0.0
2017	11	102.0	95.0	6	32.8	32.0	13	44.4	41.2	0	0.0	0.0
2018	457	969.3	391.7	106	97.9	69.7	68	59.4	54.6	5	19.1	17.4
2019	659	1621.3	836.6	165	126.5	114.0	72	141.9	107.9	12	4.6	4.6
2020	444	1543.1	351.3	250	122.5	86.4	140	120.2	108.8	10	23.5	5.8
2021	257	651.5	73.5	88	56.9	22.2	90	214.9	23.1	23	13.7	4.6
2022	447	2626.8	422.4	55	110.0	36.3	140	204.8	96.2	22	16.0	4.0
2023	3	228.9	118.0	2	35.9	35.9	4	366.1	320.3	1	40.0	40.0
2024	464	5113.4	1489.1	21	50.7	46.0	213	486.9	456.2	14	318.5	316.6

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

**Хавсралт 2. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, эдийн засгийн ангиллаар (хувийн жин)**

Он	Барилга байгууламж			Их засвар			Тоног төхөөрөмж			ТЭЗҮ		
	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
2012	71.5%	86.3%	77.0%	10.1%	3.8%	7.1%	18.4%	9.9%	15.9%	0.0%	0.0%	0.0%
2013	34.3%	61.5%	52.4%	35.8%	16.5%	22.1%	24.7%	14.4%	15.0%	5.2%	7.6%	10.5%
2014	60.0%	81.0%	69.1%	17.4%	8.6%	14.0%	22.6%	10.4%	16.9%	0.0%	0.0%	0.0%
2015	44.6%	28.9%	27.5%	16.9%	35.2%	37.2%	38.5%	36.0%	35.3%	0.0%	0.0%	0.0%
2016	45.8%	30.1%	35.3%	22.9%	46.8%	29.5%	31.3%	23.2%	35.2%	0.0%	0.0%	0.0%
2017	36.7%	56.9%	56.5%	20.0%	18.3%	19.0%	43.3%	24.8%	24.5%	0.0%	0.0%	0.0%
2018	71.9%	84.6%	73.4%	16.7%	8.5%	13.1%	10.7%	5.2%	10.2%	0.8%	1.7%	3.3%
2019	72.6%	85.6%	78.7%	18.2%	6.7%	10.7%	7.9%	7.5%	10.2%	1.3%	0.2%	0.4%
2020	52.6%	85.3%	63.6%	29.6%	6.8%	15.7%	16.6%	6.6%	19.7%	1.2%	1.3%	1.1%
2021	56.1%	69.5%	59.6%	19.2%	6.1%	18.0%	19.7%	22.9%	18.7%	5.0%	1.5%	3.7%
2022	67.3%	88.8%	75.6%	8.3%	3.7%	6.5%	21.1%	6.9%	17.2%	3.3%	0.5%	0.7%
2023	30.0%	34.1%	23.0%	20.0%	5.3%	7.0%	40.0%	54.6%	62.3%	10.0%	6.0%	7.8%
2024	65.2%	85.7%	64.5%	2.9%	0.8%	2.0%	29.9%	8.2%	19.8%	2.0%	5.3%	13.7%

**Хавсралт 3. Монгол Улсын 2012–2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчдаар (хувийн жин)**

Төсвийн ерөнхийлөн захирагчид	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Авлигатай тэмцэх газрын дарга	0.0%	0.3%	0.4%	0.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Аж үйлдвэрийн сайд	0.0%	0.0%	0.2%	0.0%	6.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.1%	1.4%	0.9%	0.5%	0.9%	0.0%	0.0%
Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд	0.0%	0.0%	0.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	0.0%	0.8%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.5%
Барилга, хот байгуулалтын сайд	0.0%	26.6%	13.5%	0.0%	2.9%	1.1%	13.5%	7.8%	10.4%	12.2%	19.7%	0.0%	0.0%
Батлан хамгаалахын сайд	0.7%	2.6%	0.3%	0.0%	0.0%	0.0%	0.1%	1.1%	0.3%	0.2%	0.8%	0.0%	1.1%
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	15.0%	39.7%	31.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	13.2%	0.0%	15.5%	29.6%	21.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Боловсрол, шинжлэх ухааны сайд	0.0%	5.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	23.6%	19.8%	20.0%	0.0%	0.0%
Боловсролын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	16.4%
Гадаад харилцааны сайд	2.5%	1.3%	0.0%	0.0%	0.0%	0.5%	0.2%	0.2%	0.0%	0.5%	0.3%	0.0%	0.2%
Гадаад харилцааны яам	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Гадаад хэргийн сайд	0.0%	0.0%	0.7%	3.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.1%
Зам, тээврийн сайд	0.0%	13.5%	17.7%	16.7%	44.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	27.9%
Зам, тээврийн хөгжлийн сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	9.4%	26.6%	8.8%	8.9%	28.1%	5.3%	0.0%
Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	41.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	1.8%	0.5%	0.1%	0.0%	1.2%	1.1%	1.3%	2.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Монгол улсын ерөнхий аудитор	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.3%	0.0%	0.0%	0.1%	0.1%	0.2%	0.1%	0.0%	0.0%
Монгол улсын ерөнхий сайд	7.8%	14.0%	1.1%	0.0%	4.7%	0.0%	0.5%	2.0%	5.5%	3.7%	1.1%	0.0%	0.0%
Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	0.1%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.0%
Монгол улсын их хурлын дарга	0.1%	0.1%	0.3%	0.0%	0.0%	0.9%	0.2%	0.1%	0.1%	0.4%	0.1%	0.0%	0.4%
Монгол улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.0%
Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%
Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.7%	5.5%	0.2%	0.0%	12.2%
Монгол улсын сайд, нийслэл улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	60.9%	0.0%
Монгол улсын тэргүүн шадар сайд	0.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.7%
Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Монгол улсын шадар сайд	0.0%	0.0%	2.0%	0.0%	0.0%	0.0%	0.6%	0.8%	0.9%	0.0%	0.4%	0.0%	1.4%
Монгол улсын шадар сайд	0.8%	0.0%	0.0%	0.0%	1.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Монгол улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.0%	0.0%
Монгол улсын шадар сайд	0.0%	2.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	2.8%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Сангийн сайд	2.5%	1.5%	2.7%	0.0%	0.0%	6.3%	6.1%	8.8%	4.2%	7.4%	2.5%	0.0%	9.8%
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	4.5%
Соёл, спорт, аялал жуулчлалын сайд	0.0%	0.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Соёлын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	28.4%	8.0%	2.8%	0.0%	0.0%
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.2%	0.0%	0.0%	0.0%	2.4%	0.0%
Төрийн албаны зөвлөлийн дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.2%
Улсын ерөнхий прокурор	0.3%	1.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.2%	0.7%	1.6%	0.1%	0.0%	0.5%
Улсын их хурлын дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.3%	0.1%	0.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Уул уурхайн сайд	0.0%	0.0%	0.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Уул уурхайн сайд	0.0%	0.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	0.0%	2.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Үндсэн хуулийн цэцийн дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Үндэсний статистикийн хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.0%
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	7.1%
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.3%	2.1%	1.6%	0.9%	3.3%	2.3%	0.0%	0.0%
Хөдөлмөрийн сайд	0.0%	0.8%	1.6%	3.7%	4.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Хууль зүй, дотоод хэргийн сайд	2.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	3.4%	5.2%	2.3%	2.0%	4.4%	3.0%	2.8%	2.3%
Хууль зүйн сайд	0.0%	4.4%	0.6%	12.1%	3.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	0.0%	0.6%	4.0%	5.6%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	5.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	11.2%	3.1%	1.3%	1.4%	4.1%	3.6%	0.0%	1.8%
Хүнс, хөдөө аж ахуйн сайд	0.0%	0.0%	5.3%	0.2%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.5%
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.3%	2.0%	0.0%
Шүүхийн ерөнхий зөвлөл	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.0%	0.0%
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	0.2%	0.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.4%	0.0%	0.0%	0.3%
Шүүхийн сахилгын хорооны дарга	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Эдийн засаг, хөгжлийн сайд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.5%	0.0%	0.0%
Эдийн засгийн хөгжлийн сайд	0.0%	7.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Эрдэс, баялаг эрчим хүчний сайд	8.8%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Эрүүл мэнд, спортын сайд	0.0%	0.0%	7.0%	26.7%	9.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Эрүүл мэндийн сайд	6.0%	6.6%	0.0%	0.0%	0.0%	13.4%	7.6%	5.9%	5.9%	16.2%	6.6%	0.0%	6.7%
Эрчим хүчний сайд	0.0%	6.6%	25.7%	1.9%	0.1%	45.9%	8.8%	4.9%	3.6%	2.8%	6.3%	20.6%	3.3%

Эх сурвалж: Монгол Улсын 2012-2024 оны төсвийн тухай хууль

**Хавсралт 4. Монгол Улсын 2012-2024 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, байршлаар (тэрбум төгрөг)**

Байршил	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024													
Аймгуудад	12	14.8	17	98.9	15	109.5	1	2.0	1	2.2	1	3.5	3	9.9	0	0.0	0	0.0	0	0.0	1	35.6	0	0.0		
Архангай	39	60.8	16	16.0	6	11.5	0	2.0	1	2.0	0	0.0	11	11.7	45	122.3	42	40.1	20	36.6	29	118.0	0	0.0	31	135.3
Баян-Өлгий	21	26.5	11	3.7	6	5.7	1	1.0	0	0.0	0	0.0	22	25.3	29	47.1	30	38.3	19	23.8	28	53.7	0	0.0	23	88.6
Баянхонгор	37	22.2	7	2.8	10	6.3	3	1.9	1	1.7	0	0.0	21	29.7	28	60.9	26	23.2	7	24.2	19	85.3	0	0.0	23	147.7
Булган	51	13.0	4	0.3	2	4.5	0	0.0	0	0.0	0	0.0	7	27.4	13	21.7	15	8.4	19	18.7	16	70.4	0	0.0	26	74.7
Говь-Алтай	14	10.3	6	2.1	5	5.7	1	1.0	0	0.0	0	0.0	12	15.1	32	51.5	29	18.6	16	16.0	31	68.6	0	0.0	20	105.6
Говьсүмбэр	8	4.7	5	2.5	0	0.0	1	1.1	0	0.0	1	2.0	3	9.4	22	17.4	3	8.4	2	3.1	3	10.9	0	0.0	10	75.4
Дархан-Уул	47	40.5	17	13.1	11	50.7	1	1.3	0	0.0	1	3.9	11	24.4	30	50.0	23	29.3	9	17.6	28	105.5	0	0.0	33	254.1
Дорноговь	27	27.1	9	1.9	5	5.2	3	2.7	1	2.1	0	0.0	5	6.6	43	52.4	17	11.6	5	27.0	9	31.9	0	0.0	14	92.9
Дорнод	79	39.5	8	2.3	9	9.4	0	0.0	0	0.0	0	0.0	12	13.2	34	43.1	17	67.7	5	29.9	17	200.7	0	0.0	12	115.9
Дундговь	30	16.0	9	2.1	2	0.0	2	1.2	0	0.0	0	0.0	11	10.1	16	27.2	9	6.4	9	15.2	13	38.0	0	0.0	19	60.0
Завхан	38	43.6	10	3.3	8	17.8	1	0.2	4	6.6	0	0.0	18	18.4	24	54.9	25	36.5	8	9.6	20	28.4	0	0.0	36	186.3
Орхон	21	20.2	7	23.4	4	2.7	1	4.0	0	0.0	1	6.0	12	23.5	20	28.5	9	14.1	7	17.9	10	33.9	0	0.0	15	66.1
Өвөрхангай	53	105.9	8	4.5	6	12.6	1	0.9	1	0.1	0	0.0	29	25.6	36	62.4	33	25.7	29	22.8	34	107.7	0	0.0	34	196.1
Өмнөговь	28	20.0	12	20.7	1	0.4	0	0.0	0	0.0	1	0.4	19	14.4	25	41.0	15	8.2	9	3.2	11	18.8	0	0.0	9	28.9
Сүхбаатар	53	20.7	8	3.2	6	17.7	1	0.0	0	0.0	0	0.0	12	18.5	18	28.8	10	5.1	7	15.2	14	33.1	0	0.0	26	133.6
Сэлэнгэ	69	27.8	15	6.6	8	16.9	1	0.1	0	0.0	0	0.0	23	18.7	37	66.5	51	22.7	11	16.3	27	69.5	0	0.0	31	117.2
Төв	58	141.8	12	4.0	8	22.9	1	1.0	0	0.0	0	0.0	23	23.0	20	84.5	20	23.3	15	39.7	18	241.5	1	138.4	30	105.9
Увс	46	31.7	7	0.5	11	4.9	1	1.5	4	1.5	0	0.0	46	32.8	53	74.6	51	25.4	30	24.2	32	67.6	0	0.0	33	123.0
Ховд	49	60.1	9	3.0	7	105.2	2	1.6	2	3.8	0	0.0	25	39.1	42	68.1	47	26.3	13	29.4	37	154.9	0	0.0	44	335.0
Хөвсгөл	55	27.9	9	32.4	12	12.3	1	1.5	0	0.0	1	0.2	20	33.7	39	53.9	52	38.2	33	25.7	36	120.4	0	0.0	53	222.7
Хэнтий	31	30.0	18	4.0	5	8.1	0	0.0	1	7.5	0	0.0	28	25.7	48	113.2	81	142.6	36	56.8	35	352.1	0	0.0	25	741.4
Улаанбаатар	55	145.9	47	104.5	40	65.8	6	9.0	6	13.6	2	62.4	12	54.3	7	70.8	6	381.4	1	4.0	7	42.4	4	352.8	9	191.1
УБ, Багануур Д	2	1.5	3	8.4	3	6.4	0	0.0	0	0.0	0	0.0	5	1.2	8	9.6	9	4.3	11	2.1	4	11.9	0	0.0	4	27.4
УБ, Багахангай Дүүрэг	0	0.0	0	0.0	1	1.3	0	0.0	0	0.0	0	0.0	1	0.7	3	5.8	0	0.0	1	0.8	1	1.3	0	0.0	3	17.7
УБ, БЗД	26	7.9	3	5.8	7	12.5	4	5.0	0	0.0	2	8.4	29	50.9	29	49.4	24	23.5	15	13.5	29	137.6	0	0.0	19	76.7
УБ, БЗД	14	10.5	12	39.2	14	14.6	2	1.4	3	7.7	0	0.0	43	69.3	44	104.9	41	64.0	26	35.0	29	72.6	0	0.0	27	148.7
УБ, Налайх Дүүрэг	6	6.7	3	3.9	1	1.2	1	0.0	0	0.0	0	0.0	5	3.8	3	14.2	2	3.6	4	6.3	6	22.8	0	0.0	3	677.8
УБ, СХД	21	17.4	1	1.4	11	10.2	1	0.9	0	0.0	1	0.1	45	110.0	43	72.0	41	65.5	11	27.2	18	61.9	1	13.6	15	64.0
УБ, Сүхбаатар Дүүрэг	18	14.2	1	0.7	17	19.5	5	1.2	5	6.6	1	1.7	28	28.8	42	66.2	34	199.5	18	33.6	20	55.6	0	0.0	18	242.5
УБ, Хан-Уул Дүүрэг	4	4.3	2	25.0	7	9.2	1	3.7	2	6.8	3	9.8	20	35.4	24	47.1	19	138.7	18	43.1	17	75.5	2	90.5	11	22.2
УБ, Чингэлтэй Дүүрэг	37	18.2	2	3.9	9	5.2	4	3.4	3	0.8	4	6.5	24	48.3	32	45.4	34	91.9	17	41.1	27	101.6	0	0.0	18	60.1
Тодорхойгүй	222	622.4	176	393.4	44	234.6	5	39.7	1	13.5	0	0.0	4	7.2	1	2.0	2	2.6	2	4.3	3	8.4	0	0.0	2	83.9
Улсын хэмжээнд	1	0.5	5	62.9	3	3.4	12	19.9	12	95.9	10	73.8	47	279.4	16	233.8	27	214.2	25	253.4	36	355.0	1	40.0	36	951.3

Боловсруулсан: Д.Баярмаа, Судлаач  
 Дугаарыг эрхэлсэн: Д.Оюунбадам,  
 Нээлттэй нийгэм форумын  
 Засаглалын хөтөлбөрийн менежер



Хаяг: Монгол Улс,  
 Улаанбаатар хот-14240,  
 Сүхбаатар дүүрэг,  
 Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207  
 Факс: 976-11-324857  
 Веб: <http://www.forum.mn>  
 И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)